

**МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон Мандал Даатгал ХК-ийн 2019 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, тус тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2020 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Мандал Даатгал ХК-ийн 2019 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг Хавсралт №1 ёсоор баталсугай.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА**



Ө. ГАНЗОРИГ

**МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

Компанийн ГУЗ-ийн
ердийн гишүүнийг томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дах заалт, 77 дугаар зүйлийн 77.1 дэх заалт, 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалт, 77 дугаар зүйлийн 77.5 дах заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.1 дэх заалтуудыг тус тус удирдлага болгон 2020 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Мандал Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Нямдаваагийн Монсор нь чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан тул 2020 оны 4 дүгээр сарын 23-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлж, Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Шаравпэлжээгийн Гантуяаг 2020 оны 4 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн бусад гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болох хүртэлх хугацаагаар томилсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Ө. ГАНЗОРИГ